

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

ЭМЯ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ

БАГАНУУР ДҮҮРЭГ: ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЖИЛ

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС:

ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУДЫН ЁС ЗҮЙН, ХАРИЛЦАА, ХАНДЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЖИЛ



ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ 2017 ОНЫ ТАЙЛАН

Багануур дүүргийн Эрүүл Мэндийн Төв нь дүүргийн 5 хорооны 29000 хүн ам, Төв, Хэнтий аймгийн хил залгаа сумдын 30000 орчим хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг Нэгдсэн эмнэлгийн бүтэц орон тооны стандартын дагуу амбулаторийн төрөлжсөн нарийн мэргэжлийн 18 кабинет, Хэвтэн эмчлүүлэх 230 ортойгоор үзүүлдэг.



	Үндсэн чиглэл	Хийсэн ажлын биелэлт
1. Эмч мэргэжилтнүүдийн ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулахын тулд хийсэн сургалт		
1.1	Эмнэлгийн мэргэжилтнүүдэд ёс зүй харилцаа хандлага /ЭМС-ын 446 тоот тушаал/	<p>Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд Төрийн албан хаагчдын хариуцлага, ёс зүй, ажлын байрны соёлыг дээшлүүлэх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн албан хаагчдыг чадавхижуулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зорилгоор 2017 оныг дүүргийн хэмжээнд “Төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан байгууллагын хэмжээнд “Эрүүл мэндийн ажилчдын хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж 3 зорилт дэвшүүлэн ажилласны 1-рт Хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх зорилт дэвшүүлсэн. Уг зорилтын хүрээнд ЭЭОДарга Н.Сэлэнгэсүлжээгээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүн бүхий ажлын хэсгийг байгуулан, 3 зорилт 8 чиглэлийн хүрээнд 29 ажлыг төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний дагуу “АЯЛАН ЯВАХ ЦОМ”-ыг ЭМТ-ийн нийт тасаг, нэгж болон ӨЭМТ-үүдээр аялуулсан.</p> <p>Ёс зүйн хэсгийн хорооны зүгээс ЭМС-ын 2013 оны 446 тоот тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх, байгууллагын ажилтнуудыг Ёс зүйн алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “ЁС ЗҮЙН КОДЧИЛОЛ БҮХИЙ ЁС ЗҮЙН ГЭРЭЭ”-г шинээр боловсруулан ёс зүйн хэсгийн хороо болон байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Удирдлагын зөвлөлийн гишүүдтэй ЭМТ-ийн дарга, тасаг нэгжийн эрхлэгч нартай Ёс зүйн хэсгийн хорооны зүгээс, тасаг нэгжийн эрхлэгч нар өөрийн хариуцсан ажилтнуудтайгаа нийт 314 ажилтантай байгуулаад байна. Мөн ёс зүйн хэсгийн хорооноос “Ёс зүйн хэсгийн хорооны хуралд оролцогчдын баримтлах зарчим”-ыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.</p> <p>Мөн ажилчдын “АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТИЙН 30%” –ийн оноог ёс зүйн харилцаа хандлагын байдлаар үнэлэдэг болгож өөрчилөлт оруулан мөрдөн ажиллаж байна.</p> <p>Байгууллагын хэмжээнд сэтгэл ханамж, санал гомдолын хайрцаг болон амаар, бичгээр хүлээн авч барагдуулан ажиллаж, 2017 онд нийт 5 өргөдөл, гомдол ирснийг эвлэрүүлэн зуучлалаар 4-ийг шийдвэрлэж, 1 асуудлыг хорооны хурал болон Удирдлагын зөвлөлд оруулан шийдвэрлэсэн.</p> <p>Өмнөх онуудад ирж байсан ёс зүйн санал гомдлын тоотой харьцуулахад харьцангуй цөөн байгаа нь тус онд ёс зүйн хэсгийн хорооны зүгээс шинээр санаачлан бүх ажилтнуудтай “ЁС ЗҮЙН ГЭРЭЭ” байгуулж, “ЁС ЗҮЙН КОДЧИЛОЛ”-ыг бий болгосны үр дүн гэж үзэж байна.</p>
1.2	Байгууллагын ёс зүй, харьцаа хандлагын удирдамжийг хэвшүүлэх сургалт	Ёс зүйн хэсгийн хорооны зүгээс хэсгийн хорооны дарга С.Алтанцэцэг Ёс зүйн сургалтыг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилчид, шинээр ажилд орсон албан хаагчдад ангилан хийж үр дүнг тооцон ажилласан.
1.3	Бие хүний төлөвшил, ёс суртахуун хандлагын сэдвээр мэргэшсэн байгууллагаас сургалт авах	“Сонгогдсон угсаа” ТББ-тай хамтран Ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалтанд Ёс зүйн хэсгийн хорооны гишүүд, мэс засал, онош зүйн тасгийн ажилтнууд нийт 45 хүн, ЭМХТ-ийн сургагч багш Л.Ширнэнгээр Эмнэлгийн ажилтны

1.4	Дээд байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд ЭТҮЧА-с мэргэжилтэн явуулж сургах, эмнэлэг дээрээ сургалт зохион байгуулах	ёс зүй сэдэвт сургалтанд нийт 100 ажилтанг тус тус хамруулсан. “Юу Би хуульчид” ХХН-ийн хуульч, эмч Ганбатыг 2017.11.15-ны өдөр орон нутагтаа ирьж ирүүлэн Монгол улсын үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулиуд болон түүнтэй холбоотой асуудлуудаар сургалт мэдээлэл хийлгэсэн.
2. Ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр зохион байгуулсан уралдаан тэмцээн		
2.1	Тасаг нэгжүүд дотооддоо ёс зүйн хэм хэмжээ чиглэлээр тестийн шалгалт авч мэдлэгийн түвшинг тогтоох	<p>15 тасаг нэгжүүд 100% ёс зүй, харьцаа хандлагын чиглэлээр тестийн шалгалтыг авсан ба эхний түвшин 62-83% байсан бол давтан шалгалтаар 76-88%-д хүрсэн. Дундаж түвшин хувь 86,5% байна.</p> <p>Тайлант хугацаанд сэтгэл ханамжийн судалгааг нийт 10 удаа 5 чиглэлээр 1560 хүнээс авсан.</p> <p>Үйлчлүүлэгчийн эерэг сэтгэл ханамжийн хувь:</p> <ul style="list-style-type: none"> ➤ 2016 онд 81% ➤ 2017 онд 96% <p>Эмч, эмнэлгийн ажилчдын эерэг сэтгэл ханамжийн хувь</p> <ul style="list-style-type: none"> ➤ 2016 онд 90% ➤ 2017 онд 92% <p>Үүнд:</p> <p><u>Хэвтэн эмчлүүлэгчдээс</u> /Байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхолын талаар/</p> <p><u>Эмч, ажилчдаас</u> /Байгууллагын дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, ажлын байрны аюулгүй байдал, дэмжлэгт орчны талаар/</p> <p><u>Амбулаторийн үйлчлүүлэгчдээс</u> /Байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхолын талаар/</p> <p><u>ӨЭМТ-ийн үйлчлүүлэгчдээс</u> /ӨЭМТ-ийн соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхолын талаар/</p> <p><u>Цахим бүртгэлээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдээс</u> /Эрүүл мэндийн төвийн цахим бүртгэлээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдээс угтах үйлчилгээний соёл, угтах үйлчилгээний ажилтнуудын ёс зүй, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тэгш байдал, ашиг сонирхлын талаар/</p>
2.2	Ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр ямар нэг хэлбэрийг ашиглан тэмцээн зохиох /дүрийн тоглолт, аха, алтан хонх/	Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний тухай ЭМС-ын 446 тоот тушаалуудаар тасаг нэгжийн эмч, ажилтнуудын дунд Алтан хонх тэмцээн, Авилгатай тэмцэх, сэргийлэх сэдвийн хүрээнд гар зургийн уралдаан

		<p>тус тус зохион байгуулж, дүүргийн албан байгууллага, ААН-үүдийн дунд зохион байгуулагдсан тэмцээнд оролцсон.</p> <p>Үйлчлэгч болон үйлчилгээний ажилтнуудын дунд ёс зүйн хэм хэмжээ, зөрчлийн тухай хууль, байгууллагын түүхээр АХА тэмцээн зохион байгуулан, “ТАНГАРАГ ӨРГӨХ” ёслолын арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор сувилагч нарын дунд багш шавийн барилдлага, тангарага өргөх ёслол, үйлчилгээний ажилтнуудыг тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгуулав.</p> <p>Залуу эмч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор ажил мэргэжлийн уралдаан, үйлчлэгч нарын дунд ажил мэргэжлийн уралдааныг тус тус зохион байгуулсан.</p>
2.3	Ёс зүйн чиглэлээр мэргэжилтнүүд хоорондын болон үйлчлүүлэгч мэргэжилтнүүдийн маргааныг эвлэрүүлэн зуучлах	<p>Ёс зүйн хэсгийн хорооны зүгээс үйлчлүүлэгч эмнэлгийн мэргэжилтнүүдийн хооронд гарсан зөрчил, маргаан, гомдол нийт 4 тохиолдлыг 100% эвлэрүүлэн ойлголцуулан зохицуулсан. Хүний нөөцийн менежер Д.Мөнгөнцацрал Ёс зүйн сургагч багшаар бэлтгэгдсэн.</p> <p>Дотрын тасаг дуут дохиотой бөгөөд Мэс заслын тасагт тайлант хугацаанд дуудах хонхыг шинээр байршуулснаар өвчтөн эмч, сувилагч болон өөрт шаардлагатай мэргэжилтэнг дуудахад хялбар, гомдол чирэгдэлгүй болсон.</p> <p>Мөн Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор дүүргийн Орон нутаг хөгжүүлэх сангийн 20,0 сая.төг-ний хөрөнгө оруулалтаар гадна болон дотор камержуулалт, нэвтрэх кодын систем бүхий хаалга, алсын зайн оношлогооны тоног төхөөрөмжөөр хангагдаж байгаа нь ялангуяа эрчимт, төрөх, мэс засал, ажилбарын өрөөнд хийгдэж буй үйл ажиллагаа хяналттай болж, гомдол маргаан гаргах асуудал эрс буураад байна.</p>
3.Ёс зүй харьцаа хандлагын хяналт үнэлгээ хийж, гарсан гомдолыг шийдвэрлэх чиглэлээр		
3.1	Эмч нарын харьцаа хандлагыг тандах, үнэлгээ хийх	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн тандалтыг нийт 8 чиглэлээр 2 удаа хийж гарсан зөрчилийг арилгасан.
3.4	Ёс зүйн хэсгийн хорооны хурлаар ноцтой тохиолдлыг хэлэлцэн шийдвэрлэх	Нийт 2 удаа ёс зүйн хэсгийн хорооны хурлыг хийсэн ба холбогдолтой 6 мэргэжилтнийг хамруулсан. Зохих арга хэмжээг тооцсон.

ТАЙЛАН БИЧСЭН:

ЁС ЗҮЙН ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.МӨНГӨНЦАЦРАЛ

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ 2017 ОНЫ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Төлөвлөгөөний дагуу “АЯЛАН ЯВАХ ЦОМ”-ыг ЭМТ-ийн нийт тасаг, нэгж болон ӨЭМТ-үүдээр аялуулж тасаг бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна.




Ёс зүйн хэсгийн хорооны зүгээс ЭМС-ын 2013 оны 446 тоот тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх, байгууллагын ажилтнуудыг Ёс зүйн алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ёс зүйн кодчиллол бүхий ёс зүйн гэрээ”-г шинээр боловсруулан, нийт ажилтнуудтай байгуулаад байна.



АХА ТЭМЦЭЭН




“Сонгогдсон угсаа” ТББ-тай хамтран Ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалтанд Ёс зүйн хэсгийн хорооны гишүүд, мэс засал, онош зүйн тасгийн ажилтнууд нийт 45 хүн, ЭМХТ-ийн сургагч багш Л.Ширнэнгээр Эмнэлгийн ажилтны ёс зүй сэдэвт сургалтанд нийт 100 ажилтанг тус тус хамруулсан.



Ёс зүйг эрхэмлэг, чанарыг дээдлэгчийг шалгаруулан ур чадварын нэмэгдэл цалин олгон хүндэт самбарт зургийг нь байршуулан алдаршуулж байна. Мөн үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг авах хайрцгийг амбулатори болон тасаг, нэгжүүдэд байршуулан ажлуулж байна.



Дотор мэдрэлийн тасаг 2016 онд хийсэн бол 2017 онд Багануур цахилгаан механикийн үйлдвэрийн хамт олны хандиваар Мэс засал эмэгтэйчүүдийн тасагт дуудлагын хонх, мэдээллийн дэлгэц, сувилагчийн бугуйн цаг /2ш/-ийг байршуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.



Хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор сувилагч нарын дунд багш шавийн барилдлага, тангарага өргөх ёслол, үйлчилгээний ажилтнуудыг тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгуулав.



Залуу эмч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулсан.



Үйлчлэгч нарын ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулсан.



Дүүргээс 2017 оныг Төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх жил болгон зарласантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор дүүргийн Орон нутаг хөгжүүлэх сангийн 20,0 сая.төг-ний хөрөнгө оруулалтаар гадна болон дотор камержуулалт, нэвтрэх кодын систем бүхий хаалга, алсын зайн оношлогооны тоног төхөөрөмжөөр хангагдаад байна.



